



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 22 өдөр

Дугаар А/357

Хэрлэн сум

Жуух бичиг хийлгэх зардалд  
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалт, Засгийн газрын 1997 оны 54 дүгээр тогтоолоор батлагдсан “Аймаг нийслэлийн Засаг даргаас олгох шагналын нийтлэг тодорхойлолт”, аймгийн Засаг даргын 2003 оны А/99, 2015 оны А/511 дүгээр захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий нутгийн хөгжлийн төлөө онцгой амжилт гаргасан иргэдийг шагнах Засаг даргын “Жуух бичиг”-ийг хийлгэх зардалд 5,592,000 (таван сая таван зуун ерэн хоёр мянган) төгрөгийн хөрөнгө зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх арга хэмжээний зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөх боломжгүй нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Ж.Гантулга)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ



Аймгийн Засаг даргын 2023 оны 06 дугаар сарын 22-ны дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт

Зардлын тооцоо

№	Нэр	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Мөнгөн дүн
1	Цэнхэр Жуух бичиг	13,000	400 ш	5,200,000
2	Улаан Жуух бичиг	14,000	28 ш	392,000
	Нийт дүн			5,592,000